

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2019 оны 10 сарын дугаар.

Тэргүүн мэдээ.

Монголын анханы их сургуулийн эмнэлэг болох Монгол Японы сургалтын эмнэлэг дээр эмнэлзүйн үйл ажиллагаа эхэллээ.



10 сарын 1-ний өдөр Улаанбаатар хотод буцалтгүй тусламжаар байгуулагдсан Монгол Японы сургалтын эмнэлэг дээр эмнэлзүйн үйл ажиллагааг эхлүүлэх ёслолын арга хэмжээ болж, амбулаторийн тусламж үйлчилгээ явагдаж эхлэв. Уг арга хэмжээнд эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн, АШУҮИС-ийн захирал Ж.Цолмон болон албаны бусад хүмүүс, оршин суугчид оролцов. Эрүүл мэндийн дэд сайдын зүгээс Япон маягийн менежментийг нэвтрүүлснээр өндөр түвшний эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх боломж нөхцөл бүрдэнэ гэж найдаж буйгаа илэрхийлэхийн хамт эмнэлзүйн үйл ажиллагаа эхэлж буй энэ өдөр нь Монгол Японы найрамдалт харилцааны түүхэнд бичигдэн үлдэх болно хэмээн мэндчилгээ дэвшүүлэв. Одоогийн байдлаар эмнэлзүйн үйл ажиллагаа нь амбулатороор хязгаарлагдаж байгаа бөгөөд дараачийн үе шат болох хэвтэн эмчлүүлэх тасгууд болон яаралтай түргэн тусламжийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах бэлтгэлийг хангах чиглэлээр ЖАЙКА-ийн зүгээс техникийн хамтын ажиллагааны төслөөр дамжуулан дэмжлэгээ үргэлжлүүлэх болно.

Төслийн хэрэгжилт.

Гэрлэн дохионы зохицуулалт хийх туршилтын төсөл хэрэгжиж эхэллээ



Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн 3 дугаар үе шатанд Улаанбаатар хотын хүндрэлтэй асуудлын нэг болох тээврийн хэрэгслээс ялгарах агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэрлэн дохионы зохицуулалт хийх туршилт төсөл хэрэгжүүлж эхлэв. Улаанбаатар хотын гэрлэг дохио нь 2010 оноос хойш ашиглагдаж байгаа боловч тээврийн хөдөлгөөний эрчим, ачааллын бодит байдалд тааруулаагүй байсан байна. Энэхүү төслөөр 2019 оны 9 сард замын хөдөлгөөний эрчмийг тодорхойлох судалгаа хийж, түүний үр дүнг үндэслэн хамгийн тохиромжтой зохицуулалтын горимыг шинэчлэн тохируулж, туршиж эхлэв. Цаашид Улаанбаатар хотын замын хөдөлгөөний хяналтын төвийн ажилтнуудад арга зүйн зөвлөмж өгөхийн хамт гэрлэн дохионы хяналтыг сайжруулах хувилбар боловсруулан хотын бусад цэгүүдэд өргөжүүлэн нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

“Монгол улсын шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх төсөл 2-р шат”-ны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах үнэлгээний багийн уулзалтын протоколд гарын үсэг зурлаа.



10 сарын 1-ний өдөр Шударга Өрсөлдөөн, Хэрэглэгчийн Төлөө Газартай хамтран хэрэгжүүлэх “Шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх төслийн 2-р шат”-ны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах үнэлгээний багийн уулзалтын протоколд гарын үсэг зурав. 2015 оноос 2018 он хүртэл хэрэгжүүлсэн төслийн эхний шатны хүрээнд өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөвлөмж өгч, байцаагч нарын чадавхийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан болно. Төслийн 2 дугаар шатны үйл ажиллагааны хүрээнд, 2020 оноос хэрэгжиж эхлэх Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай журмуудыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, албан хаагчдын чадавхийг сайжруулах, олон нийтэд шударга өрсөлдөөний мөн чанар үр шимийг таниулах, монголын зах зээлд шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгоход дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Энэ дашрамд саяхан болсон 19-р хар салхины (Хагибис) үеэр бидний төлөө санаа зовниж буйгаа мэдэгдсэн ШӨХТГ-ын даргад чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

“Монгол улсын арьс ширний үйлдвэрлэлийн хөгжил” семинар болов.



10 сарын 2-ны өдөр Монгол Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв дээр Монгол улсын арьс ширний үйлдвэрлэлийн хөгжлийн асуудлаар семинар болж, 70 гаруй хүн оролцов. Ирэх жилийн 1-р сард эхлэх ХАА-н нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах төслийг угтан зохион байгуулсан энэхүү семинарт Японы Ямагучи сангё компанийн захирал Ямагучи уригдан оролцож, тус компанийн Рассетти идээлгийн технологийг Монголын арьс ширний үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэн ашиглах боломжийн талаар танилцуулга хийв. Мөн Монгол улсын арьс ширний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай танилцуулга (холбооны гүйцэтгэх захирал), Монгол Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвийн үйл ажиллагааны танилцуулга (мэргэжилтэн Накамура) хийгдэж, оролцогчдын тавьсан олон асуултад хариулт өгөв.

Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг сайжруулах гарын авлага боловсруулах сүүлчийн сургалт болов.



Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд 9 сарын 30-ны өдрөөс 10 сарын 10-ны өдөр Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг сайжруулах гарын авлага боловсруулах сүүлчийн сургалт НДЕГ дээр болж, НДЕГ болон нийслэлийн дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн 23 ажилтан оролцов. Төсөл эхэлснээс хойш сургалтын тогтолцоог бий болгосноос гадна сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг ч бас зохион байгуулсан байна. Цаашид ажил үйлчилгээг сайжруулах гарын авлагыг эцэслэн боловсруулж, ирэх оны эхээр хэвлэн гаргахаар ажиллаж байна.

Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн мэргэжилтэн Накамура Гадаад дахь дипломат төлөөлөгчийн газрын даргын шагнал хүртэв.



10-р сарын 17-ны өдөр Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв, бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх төслийн мэргэжилтэн Накамурад (Бизнесийн хамтын ажиллагааны мэргэжилтэн) Монгол дахь Японы ЭСЯ-наас “Гадаад дахь дипломат төлөөлөгчийн газрын даргын шагнал” олгов. 8 сард Монголд анх удаа болсон Япон фестивалийг зохион байгуулсан болон өнөө хүртэл Япон Монголын найрамдалт харилцаанд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн уг шагналыг олгосон байна. Накамура мэргэжилтэнд баяр хүргэе!

ШУТИС-ийн оюутнуудад зориулсан ЖАЙКА-ийн үйл ажиллагааг танилцуулах хичээлийг зохион байгууллаа.




10 сарын 10-ны өдөр Монгол улсын ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуулийн оюутнуудад зориулсан ЖАЙКА-аас Монголд хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны чиглэл, төсөл хөтөлбөрийн талаар танилцуулах хичээлийг зохион байгуулав. Энэхүү танилцуулах хичээлд 29 оюутан оролцож, 5 багт хуваагдан “Хэрэв та ЖАЙКА-ийн ажилтан байсан бол гэр хорооллыг хөгжүүлэхийн тулд ямар төсөл хэрэгжүүлэх вэ?” гэсэн сэдвээр хэлэлцүүлэг хийж, баг тус бүр илтгэл тавив. Багууд илтгэл тавьсаны дараа ЖАЙКА-ийн төлөөлөгчийн газрын ажилтан өнөө хүртэл ЖАЙКА-гаас гэр хорооллыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж ирсэн төсөл, хөтөлбөрийн талаар товч танилцуулга

хийж, ЖАЙКА-ийн ажилтан байхын сонирхолтой талын тухай ярил.

ЖАЙКА-ын сайн дурын(JV) үйл ажиллагаа.

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга 1 (Олон улсын сувилагч нарын хурал дээр ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн илтгэл тавилаа.)



10 сарын 8-ны өдөр Улаанбаатар хотод сувилахуйн ёс зүйн сэдвээр Олон улсын сувилагч нарын хурал болж, сайн дурын гишүүн Ишизаки Намико (2017 оны 3-р ээлж, сувилагч) илтгэл тавив. Тэрээр, сувилагчийн үүрэг бол зөвхөн өвчтөн төдийгүй тэднийг асарч буй гэр бүлийн хүмүүст өвчтний биеийн байдал, эмчилгээний тухай тайлбарлаж, заавар зөвлөгөө өгөх зэргээр өвчтөний ар гэрийнхэнд санаа тавих нь чухал гэдгийг дурдсан юм. Өвчтний ар гэрийнхэн бол мэргэжлийн асрагч, сувилагч биш хэдий ч сувилагчийн анхааралд багтаж байх ёстойг, өвчтнийг түүний гэр бүлийнхэнтэй нь хамт харж хандаж байх нь мэргэжлийн сувилагч хүний үүрэг болох талаар, мөн сувилагч бүр сувилахуйн мэргэжилтэн хүний ухамсараар ажилдаа хандаж байх ёстой болохыг тайлбарласан юм. Түүнчлэн Японы сувилахуйн талаар танилцуулан, семинарт оролцсон 150 гаруй сувилагч нарт хандан өвчтнийг гэр бүлийн хүмүүстэй нь цугт нь сувилах талаар эргэцүүлэн бодох боломжийг олгосон илтгэл тавилаа.

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга 2 (Монголд анх удаа шинжлэх ухааны бүтээлийн тэмцээн зохион байгуулав.)



Дорноговь аймгийн Сайншанд хотод ажиллаж буй сайн дурын ажилтан Сато Эрико (2018 оны 3-р ээлж, бага ангийн багш)-ийн санаачилгаар Монголд анх удаа “Шинжлэх ухааны бүтээлийн тэмцээн”-ийг зохион байгуулав. Сургуулийн зуны амралтаар бага ангийн 4-5-р ангийн сурагчид өөрсдийн эргэн тойронд болж буй юмс үзэгдэлтэй холбоотой ажиглалт, туршилт явуулж, түүнийгээ нэг нүүр цаасан дээр бүтээл болгон ирүүлсэн юм. Анх удаа зохион байгуулж байгаа гэхэд тус хотын 3 сургуулиас нийт 227 бүтээл ирсэн юм. Шинэ өндөгийг ялгаж таних арга, навч газарт унах хурд, янз бүрийн хэлбэртэй утсан холбоо хийх зэргээр хүүхдүүдийн олж ирүүлсэн сэдвүүд нь өргөн хүрээг хамарч байв. 10 сарын 1-ний өдрөөс 31-ний хооронд Сайншанд хотын Соёмбо цогцолборын номын сангийн танхимд эдгээр бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, 10 сарын 19-ний өдөр уг танхимд шагнал гардуулах ёслол болж, бүтээл нь шалгарсан 17 хүүхдийг медаль болон Японы кома гэдэг тоглоомоор шагнаж урамшууллаа.



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

Сургалт Төгсөгчдийн Холбоо мод тарих үйл ажиллагаа зохион байгууллаа.



10 дугаар сарын 12-ны өдөр ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо байгаль орчноо хамгаалах, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнд мод тарих үйл ажиллагаа зохион байгууллаа. Уг арга хэмжээнд холбооны гишүүд болон ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын төлөөлөл зэрэг нийт 52 хүн оролцож, Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнгийн мэргэжилтний зааврын дагуу 80 ш чацарганы суулгац тарилаа. Энэ жил холбооны олон гишүүн гэр бүлийн хамт оролцож амралтын нэг өдрөө үр бүтээлтэй сайхан өнгөрөөлөө.

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 /E-mail: mq_oso_rep@jica.go.jp

Web: www.jica.go.jp/mongolia/index.html /FB: [JICA Mongolia](https://www.facebook.com/JICA.Mongolia)